

Хүнс, хөдөө аж ахуйн газар
2015 оны 07 дугаар сард зохион байгуулсан ажлын тайлан

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар

Аймгийн баяр наадмын Хурдан морины салбар комиссын нарийн бичгийн даргаар томилогдож, Комиссын даргын батласан төлөвлөгөөны дагуу ажлуудыг зохион байгуулж ажиллав. Уг арга хэмжээнд тус газрын 5 албан хаагч оролцож холбогдох журмын дагуу эрлийз морьдыг ялгах, шүдлэх, мал эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллалаа.

Өөрийн эзэмшлийн зам талбайн орчны 50 м газрыг тус газрын 10 албан хаагчийг оролцуулж хог цэвэрлэгээг зохион байгуулав.

Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээнд ХШҮнэлгээ хийх ажлыг зохион байгуулж Газрын даргын зөвлөлд танилцууллаа.

Газрын санхүүд дотоод аудит хийх удирдамжийг боловсруулж дотоод аудит хийх ажлыг эхлүүлэв.

Төсвийн төслийг боловсруулж холбогдох дээд байгууллагуудад хүргүүлэв. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол байхгүй байна.

Хоёр:Салбарын хүрээнд
Мал аж ахуй салбар:

Монгол Улсын Засгын газрын 2015 оны 122 тоот тогтоолоор батлагдсан “Хонь, тэмээний ноос бэлтгэж Үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмыг 4 суманд хүргүүлж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээгээр оны эхний төллөх 152,7 мянган эх мал төллөхөөс 142,1 мянган хээлтэгч төллөж төллөлт 93 хувьтай байна.

2014 оны жилийн эцэст аймгийн хэмжээнд 324241 толгой мал тоологдсон, энэ жил 139,4 мянган толгой төл хүлээн авсан бөгөөд /хонин толгойд шилжүүлсэн”-ээр 704,1 мянган толгой мал 2015-2016 онд өвөлжиж хаваржина. Эдгээр малд шаардагдах 67,6 мянган тонн өвс тэжээлийн тооцоог гаргаж даалгавар болгон 4 суманд хүргүүлээд байна.

УИХ-ын Өргөдөл гомдлын байнгын хороо болон МУЗГ-ын Хэрэг эрхлэх газраас явуулсан цахим хуралд “Хөдөө аж ахуйн цаг үеийн мэдээлэл”-ийг бэлтгэж оролцлоо. Мөн Аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан өргөтгөсөн хуралд оролцож “Өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын явц”-ын талаар мэдээлэл хийлээ.

2015 оны 7 дугаар сарын байдлаар Аймгийн хэмжээнд нийт 112 үнээнд зохиомол хээлтүүлэг хийгээд байна.

Ардын хувьсгалын 94 жилийн баяр наадмын хурдан морины комиссд цэвэр эрлийз адуу ялгах ажилд тус хэлтсийн мэргэжилтэн ажлын хэсгийн ахлагчаар ажиллалаа.

Газар тариалангийн салбар

Нийт 12809 га-д уринш боловсруулахаас 7800 га-д уриншийн 1 дүгээр боловсруулалтыг хийгээд байна.

Мотоблокын техник ашиглалтыг сайжруулах, дадлагажуулах сургалтыг УГТЭШХ, ХХААЯ-ны ТЭДС-тай хамтран зохион байгуулж нийт 12 иргэнийг хамрууллаа.

Буудайн өөрийн өртөг түүнд нөлөөлөх хүчин зүйлс, цаашид баримтлах бодлогын зөвлөмж боловсруулах нь” судалгааг ТЭДСан, ХААИСургуультай хамтран буудай тариалсан 21 аж ахуйн нэгж, иргэдээс авсан байна.

Хүнсний үйлдвэрлэлийн салбар

Аймгийн хүнсний аюулгүй байдал хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөний саналыг холбогдох байгууллагуудаас хүлээн авч, нэгтгэн гаргаад байна.

Нидерландын вант улсын төлөөлөгч нар гурил үйлдвэрлэгч, газар тариалангийнхантай уулзалтыг ХХААЯ-д 7-р сарын 17-нд хийх тухай мэдээллийг Аймгаас Өег, Өгөөж чанар, Барилтрейд ХХК-дад хүргэсэн байна.

2015 оны 7-р сарын 21-ны мэдээгээр 958,58 тн мах борлуулж, 41,4 тн махны үлдэгдэлтэй байна.

Мал эмнэлгийн салбар

Аймгийн Засаг даргын захирамжаар мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутагтаа зохион байгуулснаар 7 нэр төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд өссөн дүнгээр 212,4 мянган толгой малыг хамруулсан дүнтэй байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн орон нутгийн хувийн хэвшлийн нэгжүүдээс тарилга хийсэн мэдээ тайлан, болон акт баримтыг зохих журмын дагуу бүрдүүлэн авч санхүүжилтийг нь олгуулахаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлээд байна. Паразит өвчнөөс сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтанд өссөн дүнгээр 678,5 мянган толгой малыг хамруулсан байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд мал сүрэгт халдварт өвчин гараагүй тайван байна. Хээлтүүлэгч малын бруцеллез өвчнөөс сэргийлэх зорилгоор шинжилгээ хийх ажлыг зохион байгуулснаар одоогийн байдлаар нийтдээ 1670 толгой хуц, ухна, бухыг шинжилгээнд хамруулсан байна.

Хээлтүүлэгч малыг шинжилгээнд хамруулах ажлыг Хонгор сум сайн зохион байгуулсан бол Дархан сум хангалтгүй зохион байгуулж хамрагдвал зохих нийт хээлтүүлэгчийн дөнгөж 30 хувийг хамруулсан дүнтэй байна.

Мал эмнэлгийн арга хэмжээний болон үйл ажиллагаатай холбоотой хагас жилийн мэдээ тайланг сумдын МЭҮТасаг болон анхан шатны нэгжүүдээс хугацаандаа авч нэгтгэн МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг үржлийн газарт хүргүүлэв.

Улсын баяр наадмын үед хурдан морины уралдааныг зохион байгуулах аймгийн салбар комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан нас,шүд, үүлдэрлэг байдал зэргийг харгалзан 6 насны нийтдээ 380 гаруй морьдыг нэг бүрчлэн хэмжилт хийхээс гадна өсвөр 4 насны 290 гаруй үрээг шүдэлсэнээс гадна уралдааны замд хурдан морьдын аюулгүй байдлыг ханган ажилласан байна. Баяр наадмаар нас шүдээр 4 үрээ, үүлдэрлэг байдлаар нийтдээ 20 гаруй морьдыг уралдаанаас хассан байна.

Малын 1750 гаруй өвөлжөө, хашаа, сарвчны 90,5 мянган мкв талбай болон 7-р багийн айл өрхийн дунд байгаа жалганы хогийг цэвэрлэсэний дараа нийтийн эзэмшлийн 5600 гаруй мкв талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн байна.

Тайланг нэгтгэсэн: Бичиг хэрэг, архивын эрхлэгч Д.Ганбаяр
 Тайланг хянасан: ЗУХэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ
БАТЛАВ: ХХААГ-ЫН ДАРГА Ц.ЭНХЖАРГАЛ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
 2015 ОНЫ 08 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ
 АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажил	Огноо	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
Захиргаа удирдлагын хэлтэс				
1	Байгууллагын хагас жилийн тооллогыг хийж дуусгах.	7 сард	Тооллогын комисс	Эд, хөрөнгийн ямар нэг зөрчилгүй байна.
2	Газрын санхүүд дотоод аудит хийж тайланг газрын даргад танилцуулах.	7,8 сард	Б.Бат-эрдэнэ	Байгууллагын санхүү учрах эрсдэл буурна.
3	Архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг томилж ажиллуулах.	8 сард	Ажлын хэсэг	Архив, бичиг хэргийн стандарт, норм, дүрмийн мөрдөлт сайжирна.
Мал аж ахуйн хэлтэс				
4	2015-2016 оны хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангуулах цаг үеийн байдалтай танилцах ажлын удирдамж боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулах хэрэгжилтийг зохион байгуулах	Сардаа	МААХ	Бэлтгэл хангах чиглэлээр ажиллана .

5	Саалийн үнээтэй малчид фермерүүдийн үнээний сүүнд бүрэлдэхүүн тодорхойлох ажлыг зохион байгуулах			Шинжилгээ хийгдсэн байна.
6	Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах шинэчилэн батлуулах			Төлөвлөгөөг шинэчилсэн байна.
7	Арьс шир, ноосны урамшуулалт олгох ажлын бэлтгэл хангах сумдад заавар чиглэл өгөх			Заавар чиглэл өгч ажилласан байна.
Мал эмнэлгийн хэлтэс				
10	Бог малын боом, сахуу, томуу зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд өссөн дүнгээр 80,2 мянган толгой малыг хамруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.	Сардаа	МЭХ, орон нутгийн МЭҮН	Хамрагдвал зохих бүх малын 90-ээс доошгүй хувийг бүрэн хамруулсан байна.
11	Бог малын хамуу, бөөс ширхээс хамгаалах угаалга, туулгалтанд өссөн дүнгээр 142,5 мянган толгой малыг хамруулах ажлыг зохион байгуулах	Сардаа	МЭХэлтэс, орон нутгийн МЭҮН	Хамрагдвал зохих бүх малын 90-ээс доошгүй хувийг бүрэн хамруулсан байна.
12	Хээлтүүлэгч малын цусны шинжилгээнд хамрагдаагүй үлдсэн 650 гаруй хээлтүүлэгчийн цусыг авах ажлыг зохион байгуулах	Сардаа	МЭХэлтэс орон нутгийн МЭҮН	Бүрэн хамруулсан байна.
13	Орон нутгийн нэгжүүдийн тарилга хийсэн санхүүжилтийг олгуулах	Сардаа	МЭХэлтэс, МЭҮН-үүд	Санхүүжилтийг олгосон байна
14	Сарын ажлын мэдээ, тайланг хугацаандаа гаргах	Сардаа	МЭХэлтэс	Тайлан, мэдээг бүрэн гаргасан байна.

Хүнс, Хөдөө аж ахуйн газар